

ТӨВ БАНКНЫ ОВЕРНАИТ ХАДГАЛАМЖИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэ журмын зорилго нь Төв банк (Монголбанк)-ны тухайн хуулийн 10 дугаар зүйлийн 1, 14 дүгээр зүйлд заасны дагуу мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор банкнаас Монголбанкинд байршуулах овернаит хадгаламжийн харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 “Овернаит хадгаламж” гэж өдрийн эцэст илүүдэл нөөцтэй банкнаас “Банксүлжээ” систем хаахаас дараагийн ажлын өдрийн “Банксүлжээ” систем нээх хүртэлх хугацаанд Монголбанкинд байршуулж байгаа мөнгөн хөрөнгийг хэлнэ.
- 1.3 Банкнаас Монголбанкинд байршуулах овернаит хадгаламжаас өөр төрлийн хадгаламж энэ журамд хамаарахгүй.

Хоёр. Овернаит хадгаламжийн нөхцөл

- 2.1 Овернаит хадгаламжийн хугацаа нь “Банксүлжээ” систем хаахаас дараагийн ажлын өдрийн “Банксүлжээ” систем нээх хүртэл байна.
- 2.2 Овернаит хадгаламжийн хүүгийн хувь хэмжээг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батална.
- 2.3 Овернаит хадгаламжийн доод хэмжээг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталж тогтооно. Овернаит хадгаламжийн дээд хэмжээ нь банкны тухайн өдрийн эцсийн байдлаарх Төв банкин дахь харилцах дансны үлдэгдлээс тухайн банкинд тогтоосон заавал байлгах нөөцийн өдрөөр хангах хувийг хассан дүнтэй тэнцүү байна.
- 2.4 Монголбанк овернаит хадгаламжид барьцаа хөрөнгө байршуулахгүй.

Гурав. Овернаит хадгаламжийн үндсэн зарчим

- 3.1 Овернаит хадгаламжийн хэрэгслийг дараах шаардлагыг хангасан банк ашиглаж болно:

~~3.1.1 Монголбанкнаас тогтоох заавал байлгах нөөцийн шаардлагыг сүүлийн 3 сарын турш хангаж ажилласан;~~

[МБЕ-ийн 2013 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн А-118 дугаар тушаалаар хасав.](#)

3.1.2 Төлбөр тооцооны системд аливаа зөрчил гаргаагүй.

3.2 Монголбанкинд байршиж байгаа банкны овернаит хадгаламжийн дансны үлдэгдлийг тухайн банкны заавал байлгах нөөцийн өдрөөр болон дунджаар тооцох хангалтын хэмжээнд оруулж тооцохгүй.

3.3 Монголбанкнаас овернаит репо санхүүжилт авсан банкнаас Монголбанк овернаит хадгаламж авахгүй.

3.4 Монголбанкинд овернаит хадгаламж байршуулах гүйлгээ нь банкны тухайн өдрийн хамгийн сүүлийн гүйлгээ, харин хадгаламжийг буцаан шилжүүлэх гүйлгээ нь банкны тухайн өдрийн хамгийн эхний гүйлгээ байна.

3.5 Овернаит хадгаламж байршуулсан өдрийн дараагийн өдөр нь нийтээр амрах баярын өдөр, эсвэл долоо хоногийн амралтын өдрүүд байвал овернаит хадгаламжийн хугацааг үргэлжилсэнд тооцож, хүүг хуанлийн хоногоор тооцно.

3.6 Монголбанк мөнгөний бодлогын зорилго, чиглэлээс хамаарч банкны овернаит хадгаламж байршуулах хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж болно.

Дөрөв. Овернаит хадгаламжийн үйл ажиллагаа

4.1 Энэ журмын 3.1-д заасан шаардлагыг хангасан банк овернаит хадгаламж байршуулах хүсэлтээ Банк хоорондын цахим арилжааны систем (цаашид БХЦАС гэх)-ээр дамжуулан 17:00-17:10 цагийн хооронд Монголбанкны Валют, эдийн засгийн газар (ВЭЗГ)-т ирүүлнэ. БХЦАС-ээр ирүүлэх боломжгүй тохиолдолд факсаар, эсвэл албан бичгээр ирүүлнэ.

4.2 Монголбанк энэ журмын 4.1-д заасан хугацаанаас хойш ирсэн хүсэлтийг хүлээн авахгүй.

4.3 Банкны овернаит хадгаламж байршуулах хүсэлт нь дараах мэдээллийг агуулна:

4.3.1 Овернаит хадгаламж байршуулах огноо;

4.3.2 Банкны нэр;

4.3.3 Банкны Монголбанкин дахь овернаит хадгаламжийн дансны дугаар;

4.3.4 Байршуулах овернаит хадгаламжийн хэмжээ;

4.3.5 Банкныг төлөөлөх эрх бүхий ажилтны гарын үсэг, тамга (хүсэлтийг факсаар, эсвэл бичгээр ирүүлэх тохиолдолд).

4.4 Банк овернаит хадгаламж байршуулах хүсэлтийг БХЦАС-д оруулан баталгаажуулсан тохиолдолд цуцлах эрхгүй.

- 4.5 Монголбанк БХЦАС-д баталгаажсан хүсэлтийг тухайн банкны албан ёсны хүчин төгөлдөр санал гэж үзнэ. Банкнийг төлөөлөн БХЦАС-д нэвтэрч хүсэлт ирүүлэхтэй холбогдон гарч болзошгүй аливаа үйл ажиллагааны эрсдэлийг банк хариуцна.
- 4.6 Монголбанкны ВЭЗГ банкны хүсэлтийг хянасны үндсэн дээр овернаит хадгаламж байршуулах шийдвэрийг БХЦАС-ээр дамжуулан Монголбанкны Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (цаашид ТТБГ гэх)-т 17:15 цагаас өмнө хүргүүлнэ.
- 4.7 Монголбанкны ТТБГ овернаит хадгаламжийг банкны харилцах данснаас овернаит хадгаламжийн дансанд тухайн банкны тухайн өдрийн хамгийн сүүлийн гүйлгээгээр шилжүүлж, холбогдох нягтлан бодох бүртгэлийг хийнэ.
- 4.8 Банкны харилцах дансанд овернаит хадгаламжийн гүйлгээг хийх хангалттай хэмжээний мөнгөн хөрөнгө байхгүй тохиолдолд Монголбанк уг захиалгыг хүчингүй болгоно.
- 4.9 Энэ журмын 4.8-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд Монголбанк дараах арга хэмжээг авна:
- 4.9.1 Тухайн банкны удирдлагад сануулах албан бичгийг дараагийн ажлын өдөрт багтаан хүргүүлнэ;
 - 4.9.2 Энэ журмын 6.2-т заасны дагуу мөнгөн торгууль ноогдуулна;
 - 4.9.3 Энэ журмын 4.8-д заасан нөхцөл байдал 6 сарын туршид 3 удаа давтагдсан тохиолдолд тухайн банкны Төв банкны нээлттэй захын үйл ажиллагаа, байнгын хэрэгслийн үйл ажиллагаанд оролцох эрхийг дараалсан ажлын 5 өдөр түр хугацаанд түдгэлзүүлнэ.
- 4.10 Монголбанк овернаит хадгаламжийг хүүгийн хамт дараагийн ажлын өдөр “Банксүлжээ” систем нээгдэхэд банкны харилцах дансанд буцаан шилжүүлнэ.

Тав. Овернаит хадгаламжийн хүү тооцох

- 5.1 Овернаит хадгаламжийн хүүг дараах томъёогоор бодно.

$$I = \frac{D * i * d}{100 * 360}$$

$$I = \frac{D * i * d}{100 * 365}$$

[Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн А-24 дүгээр тушаалаар өөрчлөв.](#)

Энд:

- I - Овернаит хадгаламжийн хүүгийн хэмжээ
- D - Овернаит хадгаламжийн дүн
- i - Овернаит хадгаламжийн хүүгийн хувь хэмжээ (жилээр, хувиар)
- d - Овернаит хадгаламж байршсан хуанлийн хоногийн тоо

~~5.2 Овернаит хадгаламжийн хүүг бодохдоо “бодит хуанлийн хонөг/360” гэсэн аргачлалыг хэрэглэнэ.~~

[Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн А-24 дүгээр тушаалаар хасав.](#)

Зургаа. Бусад

- 6.1 Овернаит хадгаламжийн нягтлан бодох бүртгэлийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталсан хүчин төгөлдөр мөрдөж буй “Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу хийнэ.
- 6.2 Энэ журмын 4.8-д заасны дагуу хүчингүй болгосон овернаит хадгаламжийн дүнгээс 0.05 хувийн торгууль ноогдуулж дараагийн ажлын өдөрт багтаан тухайн банкны харилцах данснаас суутгана. Торгуулийн доод хэмжээ нь 1,000,000 (нэг сая) төгрөг, дээд хэмжээ нь 5,000,000 (таван сая) төгрөг байна.
- 6.3 Монголбанк овернаит хадгаламжийн данс нээх болон байршуулахтай холбогдуулан банкнаас аливаа шимтгэл, хураамж авахгүй.
- 6.4 Монголбанкны ТТБГ овернаит хадгаламжийн үлдэгдлийг өдөр бүрийн банкуудтай хийх өглөг авлагын тайланд тусгана.
- 6.5 Монголбанк овернаит хадгаламжийн үлдэгдэл, эзэмшигчийн тухай мэдээллийн нууцлалыг хадгална.
- 6.6 Энэ журмын 3.1 дэх заалтын биелэлтэд Монголбанк (МБСГ, ТТБГ) хяналт тавина.
- 6.7 Энэ журмын заалттай холбоотой маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд нэгдсэн шийдвэрт эс хүрвэл Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 6.8 Энэ журмыг зөрчсөн этгээдэд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.